

1. ТӨСЛИЙН ТОВЧ ТАНИЛЦУУЛГА

Төслийн тухай товч танилцуулга “Кевин Инвест” ХХК-ийн хайлуур жоншны хүдрийг флотацийн аргаар баяжуулах үйлдвэрийн төслийн хүрээнд уг үйлдвэрийг эрдэс түүхий эдээр хангах, хүдэр баяжуулалтын техник, эдийн засгийн үндэслэл боловсруулан хэрэгжүүлэх зорилт тавигдаж байна.

Уг зорилтын хүрээнд Дорноговь аймгийн Даланжаргалан сумын нутагт орших хайлуур жонш баяжуулах үйлдвэрийн техник эдийн засгийн үндэслэл хэмээх баримт бичгийг “Молор-Эрдэнэ Арвижих” ХХК боловсруулан Эрдэс баялаг, эрчим хүчний яамны дэргэдэх Эрдэс баялгийн мэргэжлийн зөвлөлөөр хэлэлцүүлж батлуулсан. ТЭЗҮ-ийн дагуу баяжуулах үйлдвэр дээр бүтээн байгуулалтын ажил хийгдэж, 2008 оноос хүдэр баяжуулах үйлдвэр ажиллаж эхэлсэн.

Энэхүү ТЭЗҮ-ийн тодотголыг Эрдэс баялгийн сайдын 2012 оны 4 дүгээр сарын 17 ны өдрийн 74 дүгээр тушаалын 7.3-д заасныг үндэслэн боловсруулав.

“Кевин Инвест” ХХК нь Монгол улсын 9019034023 бүртгэлийн дугаар бүхий гадаадын хөрөнгө оруулалттай аж ахуйн нэгжийн гэрчилгээ эзэмшдэг бөгөөд хайлуур жоншны хүдэр баяжуулах үйлдвэрлэл эрхлэх эрхийг 2007 оны 09 дүгээр сард авсан. Дорноговь аймгийн Даланжаргалан сумын засаг даргын 2012 оны 10 дугаар сарын 09-ний өдрийн А/121 тоот шийдвэрээр Дорноговь аймгийн Даланжаргалан сумын 10.8 га газрыг 5 жилийн хугацаатай олгосон. Уг зөвшөөрлийг 2017 онд Даланжаргалан сумын засаг даргын 2017 оны 02 сарын 01 өдрийн А/222 тоот шийдвэрээр 15 жилийн хугацаатай сунгасан.

Хайлуур жоншны баяжуулах үйлдвэр нь анх жилд 75 мян.тн хүдэр баяжуулах хүчин чадалтайгаар 2008 онд ашиглалтад орсон ба 2013 оноос үйлдвэрээ өргөтгөн жилд 150 мян.тн хүдэр баяжуулах хүчин чадалтай ажиллаж байна.

“Талст дөл” ХХК нь 2021 оны 11 дүгээр сард тус үйлдвэрийг түрээслэх гэрээ байгуулан ажиллаж байгаа бөгөөд бага агуулгатай олборлосон жоншийг худалдан авч баяжуулан 95%-с доошгүй агуулгатай жоншны баяжмал үйлдвэрлэж авто зам, төмөр замаар Үйлдвэр-Олон Овоо өртөө-БНХАУ-ын Эрээн хот гэсэн маршрутаар тээвэрлэнэ. 1.2. Баяжуулах үйлдвэрийн байршил Газар зүйн байршил: “Кевин Инвест” ХХК-ийн “Хайлуур жонш баяжуулах үйлдвэр” төслийн талбай Дорноговь аймгийн Даланжаргалан сумын 4-р багийн нутагт байрлана.

Баяжуулах үйлдвэрийн байршил

Газар зүйн байршил:

Даланжаргалан сум нь Дорноговь аймгийн хамгийн баруун хойд талын сум бөгөөд Монгол улсын нийслэл Улаанбаатар хотоос 305 км, Дорноговь аймгийн төв Сайншанд сумаас 156 км-ийн зайтай оршдог.

Даланжаргалан сум нь хойд талаараа Хэнтий аймгийн Дархан сумтай 76.4 км, Зүүн болон урд талаараа Айраг сумтай 133 км, баруун урд талаараа Дундговь аймгийн Өндөршил сумтай 10.2 км, баруун урд талаараа Дундговь аймгийн Баянжаргалан сумтай 30.1 км, баруун талаараа Говьсүмбэр аймгийн Шивээ-говь сумтай 39.1 км, баруун хойд талаараа Говьсүмбэр аймгийн Сүмбэр сумтай 43.3 км газраар тус тус хиллэнэ.

Багийн хилийн зааг:

Засаг захиргааны нэгжийн хувьд Элдэв, Өнгөт, Бичигт, Цомог, Олон овоот гэсэн таван багтай. Багийн хилийн заагийг хууль, журмын дагуу Аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаар албан ёсоор баталгаажуулаагүй байна. Иймд бид бүгдийн хээрийн хэмжилт тодруулалтын үр дүнгээр багийн хилийн заагийг нарийвчлан тогтоож зохих мэргэжилтэн, тухайн багийн Засаг дарга, багийн ИНХ-аар хэлэлцүүлсэн ба цаашид аймгийн ИТХ-аар батлах шаардлагатай. Багуудын газар нутгийн хэмжээний хувьд авч үзэхэд Бичигт багийн хамгийн их нутагтай 161003,4 га буюу 40.0 хувийг эзэлж байгаа бол төвийн баг болох Олон овоот баг /3357,3 га/, Цомог баг /18727,4 га/-ууд хамгийн бага газар нутагтай байна.

Хүснэгт 1. Багуудын эзлэх газрын хэмжээ, эзлэх хувь


№	Баг нэр	Талбайн хэмжээ /га/	Эзлэх хувь /%/
1	Элдэв баг	100515.7	25.0
2	Өнгөт баг	118758.3	29.5
3	Бичигт баг	161003.4	40.0
4	Цомог баг	18727.4	4.7
5	Олон овоот баг	3357.3	0.8
Нийт талбай		402362.2	100

Баяжуулах үйлдвэрийн газар зүйн байршил:

“Кевин Инвест” ХХК-ийн “Хайлуур жонш баяжуулах үйлдвэр” төслийн талбай Дорноговь аймгийн Даланжаргалан сумын 4-р баг буюу Цомог багийн нутагт байрлана.

Хүснэгт 2. Газар зүйн байршил

Талбайн булангийн цэгүүд	X	Y
1	109°05'11.5"E	45°55'50.0"N
2	109°05'16.8"E	45°56'02.8"N
3	109°05'28.3"E	45°56'00.6"N
4	109°05'23.0"E	45°55'47.4"N



Зураг 1. Баяжуулах үйлдвэрийн байршил

Төслийн талбай, түүний орчны байгаль орчин, нийгэм-эдийн засгийн төлөв байдлын товч тодорхойлолт

Нийгэм эдийн засгийн төлөв байдал

Түүхэн хөгжлийн тойм

Даланжаргалан сум Ардын хувьсгалын ялалтын дараахан нутгийн захиргаадыг байгуулахад Хан Хэнтий аймгийн Оцол сансар уулын хошуунд харьяалагдаж байгаад 1924 онд БНМАУ-ын Бага хурлын тэргүүлэгчдийн V тогтоолоор “Даланжаргалан сум” нэртэйгээр Боржигон Цэцэн вангийн хошууны нутаг "Элдэв" хэмээх газарт байгуулагдсан юм. Сумын анхны даргаар Шар хэмээх Дашдэндэв сонгогдон ажиллажээ. 1931 онд Дорноговь аймгийг байгуулахад тус аймагт харьяалагдан 1957 онд одоогийн төвлөрч байгаа

Цомог хэмээх газарт суурьшсан байна. Тус сум нутгийнхаа баруун болон хойд талаараа Дундговь, Говьсүмбэр, Хэнтий аймгуудтай, бусад талаараа өөрийн аймгийн Айраг, Иххэт сумдтай хиллэн оршдог. Нийслэл Улаанбаатар хотоос 300 км, аймгийн төв Сайншанд сумаас 156 км-т төвлөрдөг.

Хүн амын одоогийн байдал

Даланжаргалан сум нь засаг захиргааны анхан шатны Элдэв, Өнгөт, Бичигт, Цомог, Олон-Овоо гэсэн 5 нэгжтэй, 2749 хүн амтай, 821 өрхтэй, 126,7 мян.толгой малтай, эдийн засгийн голлох салбар нь мал аж ахуй ба сүүлийн жилүүдэд уул уурхайн салбар шинээр үүсэн хөгжиж байна. Сумын нутаг дэвсгэрээр Монгол орныг дамжин Ази Европ тивийг холбосон авто болон төмөр зам дайран өнгөрдөг төдийгүй, их хөлийн газар юм.

Тус суманд ИТХ-ын ажлын алба, ЗДТГ, 300 гаруй сурагчидтай 9 жилийн болон бага сургууль, эрүүл мэндийн төв, 150 гаруй хүүхэдтэй “Номт ирээдүй” цэцэрлэг, соёлын төв, цагдаагийн хэсэг, Сүгмэл эм эргэлтийн сан, Зэвсэгт хүчний 281-р байгууламж зэрэг төрийн байгууллагууд, болон хувийн хэвшлийн аж ахуйн нэгжүүд байнгын үйл ажиллагаа явуулж байна. Даланжаргалан сум усан болон утаат болор, чүнчигноров, гартаам, мана, өнгөт чулуу, төмрийн хүдэр, хайлуур жонш, нүүрс, хүрмэн чулуу, бал чулуу, шохойн чулуу, барилгын материалын түүхий эд зэрэг ашигт малтмал элбэгтэй.

Байгаль орчин

Уур амьсгал

Монгол орны уур амьсгалын мужлалтаар Дорноговь аймгийн хэмжээнд авч үзвэл төв болон өмнөд хэсгээрээ гандуу дулаан зунтай бүс, хүйтэн өвөлтэй мужид багтана. Харин хойт талаараа буюу Даланжаргалан сумын орчимд хуурай сэрүүн зунтай, хүйтэн өвөлтэй мужид хамрагдана.

Уур амьсгалыг ерөнхийд нь тодорхойлбол тус аймаг бүхэлдээ говийн бүсэд хамаардаг, говь хээр хосолсон нутагтай. Эх газрын эрс тэс уур амьсгалтай, зуны улиралд +41 хэм хүртэл халж, өвлийн улиралд -40 хэм хүртэл хүйтэрдэг. Салхины дундаж хурд 4.2-4.6 м/сек, зарим үед 35 м/сек хүртэл ширүүсэх тохиолдол бий. Дорноговь аймаг нь өргөргийн 42-46°-т орших учир нийлмэл цацрагийн хэмжээ 120-140 ккал/см² буюу 5028-5866 мДж/м² хүрдэг.

Цаг агаарын тааламжгүй нөлөөлөл болох хүчтэй цасан ба шороон шуурга, ган, зудын аюул цөөн бус удаа тохиолддог, сүүлийн жилүүдийн хуурайшилтын улмаас цөлжилтийн явц хурдасч байна. Говийн эмзэг байгалийг нөхөн сэргээх боломж хязгаарлагдмал.

Амьтны аймаг

Нутаг орны байгалийн онцлогоос шалтгаалан тус суманд 35 зүйл хөхтөн, 124 зүйлийн шувуу, 7 зүйл хэвлээр явагчид амьдардаг. Олон зүйлийн шавж, аалз, аалз хэлбэртэн, мөн бусад сээр нуруугүйтний зүйлүүд байдаг. Ургамлын хувьд цөлөрхөг хээрийн бүлгэмдэл зонхилно.

Шарилжны төрлийн ургамлууд түгээмэл тохиолддог ба үүнээс хамгийн элбэг болох агиас шаргал шарилж, олон зүйлийн цэцэгт ургамлаар баялаг.

Тухайлбал: Цахилдаг, сараана, гоо юлт, 2 наст гол гэсэр, сэдэргэнэ, хонгорзул, сөөгөн эмгэн шилбэ, имт гичгэнэ, хатны шар цэцэг, баглуур, өргөст бутаргана, үлтэн могойн идээ, ногоон удвал, улаан бударгана зэрэг ургамлууд элбэг тохиолдох бөгөөд хуурайшилтай жилүүдэд өвслөг болон бутлаг ургамал нилээд тэсвэртэй ургадаг.

3. ТӨСЛИЙН ГОЛ БА БОЛЗОШГҮЙ СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙН ТОВЧ ТОДОРХОЙЛОЛТ

Төслийн явцад агаарын бохирдол нэмэгдэх, хөрс элэгдэх, ургамлан бүрхэвч талхлагдах, дуу чимээний бохирдолтыг орчиндоо үүсгэх болон хог хаягдал ялгаруулах зэрэг гол сөрөг нөлөөлөл багагүй учрах болно.

Эдгээрийн эрчим, үр нөлөө нь төсөл хэрэгжих явцад их боловч нөлөөллийг бууруулах, байгаль хамгаалах төлөвлөгөөг сайтар гүйцэтгэн цаашид хяналт шинжилгээний хөтөлбөрийг зөвлөмжийн дагуу цаг тухайд хийж хэвшвэл гол сөрөг нөлөөллийг бууруулах боломжтой юм.

Агаарын чанарт үзүүлэх нөлөөлөл түүнийг бууруулах арга хэмжээ

Хүдэр ачих, буулгах түүхий эдийн овоолго болон хүдэр тээвэрлэлт хийх хүнд даацын машин зэргийн нөлөөллөөр их хэмжээний сул шороо дэгдэж агаарт байх нарийн ширхэгтэй тоосонцорын агууламж нэмэгдэх хандлагатай. Хүдэр бутлах, овоолго хийх, ачих зэрэг технологийн процессийн явцад тоос ихээр гарч агаарт дэгддэг.

Хүдэр бутлах тээрэмдэх үйл ажиллагаа нь үйлдвэрийн байранд битүү орчинд явагдах тул агаарын чанарт онцгой нөлөө үзүүлэхгүй. Тиймээс тээврийн хэрэгслийн хөдөлгөөн болон үйлдвэрийн талбай дахь хүдрийн овоолгоос хийсэх тоосны нөлөөллийг хяналтанд авч, эрх бүхий байгууллагаас стандартчилж тогтоосон зөвшөөрөгдөх дээд хэмжээнээс давуулахгүй байх тал дээр анхаарч үйл ажиллагаагаа явуулна.

Газрын доорх усанд үзүүлэх нөлөөлөл, түүнийг бууруулах арга хэмжээ

Баяжуулах үйлдвэрийн үйл ажиллагаанд ашиглах усны тооцооллоос авч үзэхэд 17 л/сек ус зарцуулж байна. Үйлдвэрт ашиглах өрөмдмөл худгийн 1-3-р түвшний бууралт 12-30 м усны ундарга нь 3-4.8 л/сек байна. Үүнээс үзэхэд жонш баяжуулах үйлдвэрт ашиглах гүний усны нөөц нь хязгаарлагдмал, нөхөгдөх хэмжээ бага зөвхөн улирлын чанартайгаар хур тунадас туйлын бага унадаг, түүнээс үүдэн газрын гүний усны хуримтлал маш удаан бий болдог, байнгын урсгалтай гол, горхи байхгүй зэрэг онцлогийг харгалзан уг төслийн үйлдвэрлэлд зарцуулагдах усны хэмжээ нь гүний усны нөөцөд сөргөөр нөлөөлж болзошгүй.

Тиймээс тус баяжуулах үйлдвэр нь ашиглах усны хэрэглээг багасгах, дахин ашиглах эргэлтийн системийг боловсронгуй болгох, төслийн үйл ажиллагаанаас гүний усны нөөц багасахаас урьдчилан сэргийлж байнгын хяналт шинжилгээний ажлыг явуулна.

Газрын гадарга, хөрсөн бүрхэвчид үзүүлэх нөлөөлөл, түүнийг бууруулах арга хэмжээ

Жонш баяжуулах үйлдвэр нь Дорноговь аймгийн Даланжаргалан суманд 2009 оноос одоог хүртэл дулааны улиралд үйл ажиллагаагаа тасралтгүй явуулж ирсэн. Тус үйлдвэрийн эдэлбэр газар нь 1.0 га бөгөөд үүний 65% нь барилгажсан талбай эзэлдэг. Жонш баяжуулах үйлдвэрийн онцлогоос шалтгаалан үйлдвэрийн талбайд хүнд даацын автомашины хөдөлгөөний эрчимшил их, хүдрийн овоолго бүхий талбай, уурын зуухны нүүрсний талбай зэргээс тоосжилт үүсдэг.

Дээрх нөхцөл байдлын үүднээс үйлдвэрийн эдэлбэр талбайн өнгөн хөрс хууларч, суларсан, ургамлан бүрхэвч ихэнхи хэсгээр устсан ба үржил шимгүй хурдас бүхий шороон гадарга үүссэн. Мөн хүнд даацын машин техникийн хөдөлгөөний улмаас хөрс ургамлыг тоосоор дарах, гэмтээх, хөрсийг дагтаршуулах зэргээр талхагдалд оруулсан.

Ургамлан нөмрөгт үзүүлэх нөлөөлөл, түүнийг бууруулах арга хэмжээ

Үйлдвэрийн талбайн булан, хашаалсан талбайн захаар хөл газрын ургамал ургасан. Хөл газрын ургамал нь дасан зохицох, мэнд үлдэх чадвар сайтайн дээр шим тэжээлийн бодис ус чийгийг ашиглах чадвар өндөр зэрэг хэд хэдэн давуу талтай байдаг. Тиймээс тухайн бүс нутгийн ургамлын бүлгэмдэлд өөрчлөлт орох нөхцөл бүрдэж болзошгүй юм.

Автомашин техникүүдээс агаарт ялгарах хүхэрлэг хий, азотын болон нүүрсхүчлийн давхар исэл, мөн бусад химийн нэгдэл, нарийн ширхэгтэй тоосны дэгдэлт нь орчны хөрс, ургамлыг бохирдуулан улмаар биоценозод сөрөг нөлөө үүсгэх талтай байж болно.

Амьтны аймагт үзүүлэх нөлөөлөл, түүнийг бууруулах арга хэмжээ

Жонш баяжуулах үйлдвэр нь Даланжаргалан сумын төвөөс 2 км-ийн зайтай, харьцангуй суурьшлын бүсэд байрладаг тул сээр нуруутан амьтдад шууд сөрөг нөлөө үзүүлэхгүй. Харин үйлдвэрийн үйл ажиллагааны нөлөөгөөр хөрсний мизо болон микро фауны амьтдад сөргөөр нөлөөлж болзошгүй юм.

4. БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТУХАЙН ЖИЛИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ГОЛ ЗОРИЛТ

Тус баяжуулах үйлдвэрийн төслийн БОННУ-д тусгасан Монгол улсад хүчин төгөлдөр мөрдөгдөж буй төслийн үйл ажиллагаатай холбогдох байгаль орчныг хамгаалах хууль, эрхзүйн орчин, төслийг хэрэгжүүлэх явцад зайлшгүй мөрдөж ажиллах хуулийн хориглосон, хязгаарласан зүйл, заалтууд, төрийн эрх бүхий байгууллагаас гаргасан дүрэм, журам, стандарт, Монгол Улсын нэгдэн орсон конвенциудын холбогдох шаардлагуудыг үйл ажиллагаандаа хэрэгжүүлж, тэдгээр эрх зүйн баримт бичгүүдийг мөрдлөг болгон ажиллана.

Үйлдвэрлэлийн үйл ажиллагаанаас үүдэлтэй гэнэтийн осол эрсдэлээс урьдчилан сэргийлж, хүрээлэн буй орчин болоод нийгэмд үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулж болох бүх талын арга хэмжээг авч эрүүл аюулгүй, байгальд ээлтэй технологийг нэвтрүүлж ажиллана.

Тус төлөвлөгөө нь тухайн төслийг хэрэгжүүлэх үйл ажиллагааны орон зай, цаг хугацааг бүрэн хамарсан байхаас гадна байгаль орчныг хамгаалах талаар авах удирдлага зохион байгуулалтын болон сөрөг нөлөөллийг бууруулах, арилгах арга хэмжээ, дүйцүүлэн хамгаалах арга хэмжээ, нөхөн сэргээлтийн арга хэмжээ зэрэг төлөвлөгөөнд тусгагдсан ажлуудыг хэрэгжүүлэхэд шаардагдах хөрөнгө зардал, хариуцан гүйцэтгэх эзэн, хэрэгжүүлэх хугацаа ба давтамжийг бодитойгоор тооцож тусгасан.

Байгаль орчинд нөлөөлөх байдлын нарийвчилсан үнэлгээний хүрээнд байгаль орчныг хамгаалах төлөвлөгөөг боловсруулахдаа сөрөг нөлөөллийг бууруулах, арилгах чиглэлээр тайланд тусгасан зөвлөмжийг хэрэгжүүлэх арга хэмжээг бүрэн хамарсан.

Энэхүү төслийн байгаль хамгаалах төлөвлөгөөг боловсруулахдаа “Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай” хууль, Байгаль орчин, аялал жуулчлалын сайдын 2019 оны 10 дугаар сарын 29-ний өдрийн А-618 тоот тушаалаар батлагдсан “Байгаль орчны менежментийн төлөвлөгөө боловсруулах, хянан батлах, тайлагнах журам” -ын дагуу боловсруулсан болно.

“Кевин Инвест” ХХК-ний Дорноговь аймгийн Даланжаргалан сумын нутагт хэрэгжиж буй “Жонш баяжуулах үйлдвэр” төслийн 2026 онд хэрэгжүүлэх байгаль орчны менежментийн төлөвлөгөө

2026

Хүснэгт 3. Сөрөг нөлөөллөөс урьдчилан сэргийлэх, бууруулах арга хэмжээний төлөвлөгөө

Гол ба болзошгүй сөрөг нөлөөлөл	Урьдчилан сэргийлэх бууруулах арга хэмжээ	Арга хэмжээний цар хүрээ	Хэмжих нэгж	Тоо хэмжээ	Нэгжийн үнэ, төг	Нийт зардал, төг	Баримтлах стандарт, аргачлал
Тайлбар: (*)- гэрээний дүн болон аж ахуйн зардалд тусгасан мөнгөн дүн							
Агаар орчинд үзүүлэх нөлөөллийг бууруулах чиглэлээр							
Үйлдвэрийн дотоод болон гадаад тээврийн замаас үүсэх тоосжилт, Машин механизмын дотоод шаталтаас үүсэх хорт хий	Тээврийн хэрэгслийн хурдыг хязгаарлах тэмдэг тэмдэглэгээ байршуулах	Үйлдвэрийн зам	ш	3	30,000	90,000*	✓ MNS 4585 :2016 Агаарын чанар. Техникийн ерөнхий шаардлага, ✓ Агаарын тухай хууль, 2012, ✓ MNS 5013 :2001 Бензинээр ажилладаг хөдөлгүүртэй автомашин Утааны найрлага дахь хорт бодисын зөвшөөрөх дээд хэмжээ,
	Олон шинэ салаа зам үүсгэхгүй байх, тээврийн хэрэгслийн хурдыг хязгаарлаж түүнд хяналт тавих	Үйлдвэрийн зам					
	Тоосжилт бууруулах төлөвлөгөөт усалгааг 4-9 саруудад хур борооны давтамжаас хамааруулах усалгаа хийх	Үйлдвэрийн дотоод зам	м3	-	-	500,000*	
	Машин техникийн засвар үйлчилгээг хугацаанд нь хийх, оношилгоонд хамруулах, чанартай түлш ашиглах	Үйлдвэрийн машин механизм				500,000*	
Гадаргын болон газар доорх усанд үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах чиглэлээр							
Технологийн хэрэгцээнд, унд ахуйн хэрэгцээнд, тоосжилт зам усалгаанд, ногоон байгууламж, уурын зууханд газрын	Ашиглаж байгаа худгуудийн тоолуурын баталгаажуулалтыг сар бүр хийх	Худгийн тоолуур	Удаа		20,000*	Усны тухай хууль MNS 0900:2018 Ундны ус. Эрүүл ахуйн шаардлага, чанар, аюулгүй байдлын үнэлгээ Газрын доорх ус бохирдуулагч бодис, элементийн	
	Тоолуур эвдэрсэн тохиолдолд засварлах, солих акт үйлдэх	Худгийн тоолуур эвдэрсэн тохиолдолд			100,000*		

“Кевин Инвест” ХХК-ний Дорноговь аймгийн Даланжаргалан сумын нутагт хэрэгжиж буй “Жонш баяжуулах үйлдвэр” төслийн 2026 онд хэрэгжүүлэх байгаль орчны менежментийн төлөвлөгөө

2026

<p>доорх ус ашигласнаар нөөц горимд нөлөөлөх</p>	<p>Хаягдлын сангийн аюулгүй ажиллагааг ханган үйл ажиллагаа явуулах, хяналт мониторингийн цэгт тогтмол хяналт шинжилгээ хийж байх</p>	<p>Хаягдлын сан болон бохир хадгалах цооног</p>	<p align="center">50,000*</p>	<p>зөвшөөрөгдөх дээд хэмжээ</p>
<p>Бохир хадгалах цооног, шугам хоолойд тогтмол хяналт шалгалт хийж, эвдрэл гэмтэл гарсан тохиолдолд нэн даруй засах арга хэмжээ авах</p>	<p>Хаягдлын сан болон бохир хадгалах цооног</p>	<p align="center">100,000*</p>		
<p>Төслийн талбайтай хамгийн ойр байрлах булгийн хогийг цэвэрлэх</p>	<p>Далантүрүү рашаан</p>	<p align="center">200,000*</p>		
<p align="center">Газрын гадарга, Хөрсөн бүрхэвчид үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах чиглэлээр</p>				
<p>Машин Тээврийн хэрэгслүүдийг н явах эд ангиуд гэмтэх, хүний болгоомжгүй үйлдлээс ШТМ гоожиж, асгарсан тохиолдолд тухайн орчмын хөрсөн бүрхэвчийг бохирдуулж болзошгүй</p>	<p>Машин, тээврийн хэрэгслийн засвар үйлчилгээг зөвхөн засварын талбай дээр хийх</p>	<p>Засварын цэг</p>	<p align="center">60,000*</p>	<p>Сонгож авсан шингээгч материалгыг хэрэглэх зааварчилгаа ШТМ асгаралтаас урьдчилан сэргийлэх, хязгаарлах талаар баримталж буй үйлдвэрийн дотоод дүрэм, журам</p>
<p>Гоожиж, асгарсан ШТМ-ыг шингээн авах материалыг ажлыг талбайд бэлэн байлгах, мөн асгаралтаас сэргийлэх, асгаралтын үед авах арга хэмжээ, асгаралтыг мэдээллэх, хязгаарлах, цэвэрлэх дотоод журам боловсруулж, мөрдүүлж ажиллах хэрэгтэй.</p>	<p>Хөдөлгөөнд оролцож буй бүх тээврийн хэрэгсэл</p>	<p align="center">300,000*</p>		
<p>Ахуйн болон бусад хог хаягдлыг зориулалтын бус газарт хаях, зориулалтын бус саванд хадгалах</p>	<p>Хог хаягдлыг зориулалтын цэгт хаях, ангилан ялгах</p>	<p>Үйлдвэрийн хог хаягдлын цэг</p>	<p align="center">150,000*</p>	<p>Хог хаягдлын тухай</p>

“Кевин Инвест” ХХК-ний Дорноговь аймгийн Даланжаргалан сумын нутагт хэрэгжиж буй “Жонш баяжуулах үйлдвэр” төслийн 2026 онд хэрэгжүүлэх байгаль орчны менежментийн төлөвлөгөө

2026

зэргээс хөрс бохирдох				
Ургамал нөмрөг, амьтны аймгийг хамгаалах чиглэлээр				
Тээврийн хэрэгслийн болон хүний зорчих хөдөлгөөний үед үүсэх тоосжилт орчны ургамлан нөмрөгийн урга чадварт нөлөөлөх	Явган хүний замыг засаж сайжруулах	Үйлдвэрийн явган хүний зам	230,000*	Байгалийн ургамлын тухай хууль, (1995)
	Тухайн орчин дахь ургамлын бүртгэл хийх	Үйлдвэрийн орчимд	20,000*	
НИЙТ			1,000,000	

Хүснэгт 4. Хог хаягдлын менежментийн төлөвлөгөө

№	Урьдчилан сэргийлэх, бууруулах арга хэмжээ	Арга хэмжээний цар хүрээ	Нэгжийн өртөг, төг	Нийт зардал, төг	Хэрэгжүүлэх хугацаа, давтамж	Баримтлах стандарт, аргачлал	
Ахуйн хог хаягдал							
1	Ахуйн хог хаягдлын гэрээг Даланжаргалан сумын ЗДТГ-тай байгуулах	Даланжаргалан сумын ЗДТГ	Төслөөс үүсэх ахуйн хог хаягдал	-	-	2026 он	Хог хаягдлын тухай хууль, эрүүл ахуйн тухай хуулийн 4.4.3 зүйл, 13.1.6 зүйл, Хог хаягдлын улсын тоо бүртгэл хөтлөх, тайлагнах журам
2	Ажилчдын кемпээс гарч буй хуванцар савыг цуглуулж, дахин боловсруулах ААН нийлүүлэх	Хог хаягдлын менежмент хэрэгжүүлэх	Төслийн хуванцар цуглуулах цэгт	-	-	2026 он	

**“Кевин Инвест” ХХК-ний Дорноговь аймгийн Даланжаргалан сумын нутагт
хэрэгжиж буй “Жонш баяжуулах үйлдвэр” төслийн 2026 онд хэрэгжүүлэх
байгаль орчны менежментийн төлөвлөгөө**

2026

			цугларсан хуванцар			
Аюултай хог хаягдал						
3	Ашигласан тос маслыг мэргэжлийн байгуулгатай гэрээ хийж зайлуулах	“Хай би ойл” ХХК	300л-500л	Гэрээний дүнгээр	2026 он	
4	Химийн бодисын үлдэгдэл сав, баглаа шуудайг мэргэжлийн байгуулгатай гэрээ хийж зайлуулах	“Түмэн эгшиг” ХХК	Химийн бодисын сав баглаа, шуудай	2,500,000*	2026 он	
5	Баяжуулах үйлдвэрээс үүсэн хаягдал төмрийг дахин боловсруулах үйлдвэрт нийлүүлэх	Гэрээт ААН	Төмөр хадгалах цэгт үүссэн хаягдал төмөр	Гэрээний дүнгээр		
Шингэн хог хаягдал						
6	Баяжуулах үйлдвэрт хуримтлуулсан ахуйн бохир усыг соруулах, ариутгах	Гэрээт ААН	Ахуйн бохир ус	500,000*	2026 он	
НИЙТ					318,000	

“Кевин Инвест” ХХК-ний Дорноговь аймгийн Даланжаргалан сумын нутагт хэрэгжиж буй “Жонш баяжуулах үйлдвэр” төслийн 2026 онд хэрэгжүүлэх байгаль орчны менежментийн төлөвлөгөө

2026

Хүснэгт 5. Дүйцүүлэн хамгаалах арга хэмжээний төлөвлөгөө

№	Дүйцүүлэн хамгаалах зорилт	Дүйцүүлэн хамгаалах арга хэмжээ	Нэгж зардал /төг/	Нийт зардал /төг/	Хэрэгжүүлэх хугацаа ба давтамж	Баримтлах стандарт, аргачлал
1		Дүйцүүлэн хамгааллын арга хэмжээг орон нутгийн захиргаатай зөвшилцсөний үндсэн дээр сумын орчны бохирдлыг бууруулах зорилгоор хог хаягдал тээвэрлэх машины дэмжлэг үзүүлэхээр ажиллах санал авсан.	30,000,000*		2026 он	Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай хууль 3.1.11-р зүйл, 8.4.6-р зүйл, 9.6-р зүйл
Нийт				30,000,000*		

Хүснэгт 6. Ногоон байгууламжийн төлөвлөгөө

№	Ногоон байгууламжийн төлөвлөгөө	Тоо хэмжээ	Нийт зардал /төг/	Хэрэгжүүлэх хугацаа ба давтамж	Баримтлах стандарт, аргачлал	
1	Даланжаргалан сумын мод тарих талбайд 250ш хайлаас мод тарих	250 ш	1,000,000*	2-3 улиралд	Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай хууль 3.1.11-р зүйл, 8.4.6-р зүйл, 9.6-р зүйл	
Нийт				1,000,000*		

Тайлбар: (*)- гэрээний дүн болон аж ахуйн зардалд тусгасан мөнгөн дүн

Хүснэгт 7. Осол эрсдэлийн менежментийн төлөвлөгөө

Болзошгүй аюул осол, сөрөг нөлөө	Урьдчилан сэргийлэх бууруулах арга хэмжээ	Арга хэмжээний цар хүрээ	Хэмжих нэгж	Тоо хэмжээ	Нэгжийн үнэ, төг	Нийт зардал төг	Баримтлах стандарт, аргачлал
Байгалийн гамшиг, аюулт үзэгдлээс үүдэн болзошгүй сөрөг нөлөөллийг бууруулах							
Гал түймрийн улмаас үйл ажиллагаа доголдох, зогсох	Ил задгай гал гаргахгүй байх, хэрэгцээт газруудад галын самбар, багаж хэрэгслийг байршуулах	Төслийн хүрээнд	ш	2	100,000	200,000	Галын аюулгүй байдлын тухай хууль, 3-р зүйл, MNS 5566:2005 MNS 0640:89 MNS 639:89
	АҮХТ-г батлуулах, төлөвлөгөөний дагуу ажиллах	АҮХТ	-		100,000*		
	Гал утраагуурын хэвийн ажиллагааг хянах	Тогтмол	-		150,000*		
Үйлдвэрийн ослоос урьдчилан сэргийлэх							
Ослын улмаас хүний эрүүл мэнд, амь насанд сөргөөр нөлөөлж үйлдвэрлэлийн үйл ажиллагаа доголдох, зогсох	Хөдөлмөр хамгаалал аюулгүй ажиллагааны дүрэм журмыг сахиулж, хэрэгжилтэд хяналт тавих	Тогтмол	-		50,000*		MNS 4990:2000 MNS 4969:2000 Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хууль, 15 р зүйл
	Хөдөлмөр хамгаалал аюулгүй ажиллагааны сургалтыг тогтмол хугацаанд гүйцэтгэх	Тогтмол			ХАБЭА төлөвлөгөөний дагуу		
	Ажиллагсдын хөдөлмөр хамгааллын хувцас хэрэгслээр хангах	Үйлдвэрийн ажилчид			10,000,000*		
Баяжуулах үйлдвэрт осол эрсдэл үүссэн тохиолдолд авах арга хэмээ							
Осол эрсдэл үүссэн тохиолдолд хүний эрүүл мэндэд сөргөөр нөлөөлж,	Баяжуулах үйлдвэрийн бүсэд осол гарах үед удирдлагад мэдэгдэх, ослын түвшинг тогтоож аюулын зэргээс	Осол эрсдэл үүсэх үед	-		ХАБЭА төлөвлөгөөний дагуу		MNS 4990:2000 MNS 4969:2000 Хөдөлмөрийн аюулгүй байдал,

“Кевин Инвест” ХХК-ний Дорноговь аймгийн Даланжаргалан сумын нутагт хэрэгжиж буй “Жонш баяжуулах үйлдвэр” төслийн 2026 онд хэрэгжүүлэх байгаль орчны менежментийн төлөвлөгөө

2026

Үйлдвэрлэлийн үйл ажиллагаа доголдох, зогсох	хамаарч түргэн шуурхай арга хэмжээ авах				эрүүл ахуйн тухай хууль, 15 р зүйл
	Анхны тусламжийг цаг алдалгүй үзүүлж, шаардлагатай тохиолдолд түргэн тусламж, сумын эмнэгэлт хүргүүлэх	Осол эрсдэл үүсэх үед	-	ХАБЭА төлөвлөгөөний дагуу	
Баяжуулах үйлдвэрт химийн бодис асгарах	Химийн бодис алдагдсан тохиолдолд цааш тархахаас сэргийлж шингээгч материалд шингээн авч, бохирдсон хөрсийг авч тусгай цэгт цуглуулах. Мөн хөрсийг элс хайргаар саармагжуулж байх	Осол эрсдэл үүсэх үед	-	ХАБЭА төлөвлөгөөний дагуу	
Гал түймэр гарсан үед	Гал түймрийн үед баяжуулах үйлдвэрийн аврах бүлгийг цуглуулж АҮХТ дагуу шуурхай арга хэмжээ авах	Осол эрсдэл үүсэх үед	-	ХАБЭА төлөвлөгөөний дагуу	
НИЙТ				200,000	

“Кевин Инвест” ХХК-ний Дорноговь аймгийн Даланжаргалан сумын нутагт хэрэгжиж буй “Жонш баяжуулах үйлдвэр” төслийн 2026 онд хэрэгжүүлэх байгаль орчны менежментийн төлөвлөгөө

2026

Хүснэгт 8. Орчны хяналт шинжилгээний хөтөлбөр

Хяналт шинжилгээ хийх үзүүлэлт	Байршил	Хэрэгжүүлэх хугацаа давтамж	Зардал (төг)	Нийт зардал төг	Баримтлах стандарт, аргачлал
Тайлбар: (*)- гэрээний дүн болон аж ахуйн зардалд тусгасан мөнгөн дүн					
<i>Агаарын чанар</i>					
Зөөврийн багажаар: Агаар бохирдуулагч хийнүүд: SO ₂ , NO ₂ Тоосонцор: PM ₁₀ , PM _{2.5}	Ажилчдын байр, Үйлдвэрийн бүс, Хаягдлын далан	Жилд 2 удаа 6 болон 9 сард	50,000	300,000	MNS 4585:2016 MNS:3384:1982 MNS:4048:1988 MNS 4585:20216 MNS:3384:1982 MNS 4048:1988
<i>Гадаргын болон газар доорх ус</i>					
Гүний худгийн усны чанар: рН, TDS, нийт хатуулаг, ууссан хүчилтөрөгч, БХХ, ХХХ, Са, Mg, Na, К, SO ₄ , NO ₂ , NO ₃ , NH ₄ , As, Cd, Cu, Hg, Pb, Zn, Cr, Fe, N	Гүний худаг	Улиралд 1 удаа= Жилд 4 удаа	28,000	112,000	MNS (ISO) 5667-5:2001- усны чанар-дээжлэлт
	Ундны ус	Улиралд 1 удаа= Жилд 4 удаа	28,000	112,000	
Ахуйн бохир усны цоонгийн бохир ус: рН, Ж/б, ХХХ, БХХ, NH ₄ , NO ₂ , NO ₃ , N-нийт, Рэрд	Ахуйн бохир ус	Жилд 3 удаа		174,000	MNS (ISO) 5667-10:2001 “Усны чанар.дээж авах. 10-р бүлэг. Хаягдал уснаас дээж авах заавар”
<i>Хөрсөн бүрхэвч</i>					
Хөрсний бохирдол, ялзмагийн агууламж: рН,, чийгшил, ялзмаг, NH ₄ , NO ₃ , SO ₄ , P ₂ O ₅	Үйлдвэрийн бүс Кемп Харьцуулах хөрс	Жилд 2 удаа	30,000	180,000	MNS 5850 : 2018 Хөрсний чанар. Хөрс бохирдуулагч бодис, элементүүдийн

“Кевин Инвест” ХХК-ний Дорноговь аймгийн Даланжаргалан сумын нутагт хэрэгжиж буй “Жонш баяжуулах үйлдвэр” төслийн 2026 онд хэрэгжүүлэх байгаль орчны менежментийн төлөвлөгөө

2026

Хөрсөнд агуулагдах хүнд металлын агууламж: Ni, Cd, Pb, Cu, Zn, Cr	Кемп Ахуйн хог хаягдал Засварын төв Химийн хог цуглуулах Хүдрийн овоолго Баяжуулах үйлдвэр ШТС	Жилд 2 удаа 7 цэгт	40,000	560,000	зөвшөөрөгдөх дээд хэмжээ
Ургамлан нөмрөг					
Ургамлын зүйлийн бүрдэл, ургамлын тусгаг бүрхэц, арви, 1 м2 талбайгаас газрын дээрх биомасс авах	Ногоон байгууламж байгуулсан талбай зам дагууд 1 цэгт, Үйлдвэрийн талбай орчимд 1 цэгт,	Жилд 1 удаа 2 цэгт	50,000*		Шугаман цэгийн арга(Раменскийн тор)
Дуу чимээ					
Дуу чимээний түвшинг хэмжих	Ажилчдын кемп, бутлуур, баяжуулах үйлдвэр	Жилд 1 удаа	50,000*		
НИЙТ			1,438,000		



Зураг 2. Хөрсний дээж авах цэг



Зураг 3. Ургамал болон агаарын дээж авах цэг

**“Кевин Инвест” ХХК-ний Дорноговь аймгийн Даланжаргалан сумын нутагт
хэрэгжиж буй “Жонш баяжуулах үйлдвэр” төслийн 2026 онд хэрэгжүүлэх
байгаль орчны менежментийн төлөвлөгөө**

2026

Хүснэгт 9. Байгаль орчны менежментийн төлөвлөгөөг хэрэгжүүлэх удирдлага, зохион байгуулалтын төлөвлөгөө

№	Төлөвлөсөн арга хэмжээ	Урьдчилан тооцсон төсөв	Хэрэгжүүлэх хуваарь			Хариуцсан албан тушаалтан	Тайлбар
			2026 он				
			Сар 1-3	Сар 4-7	Сар 8-12		
1	Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний хэрэгжилтийг хангах, зохион байгуулах	-	X			БО мэргэжилэн	БОМТ-нд тусгасан арга хэмжээг хэрэгжүүлсэн байна
2	Газар, ус ашигласны болон бусад төлбөр	Гэрээний дүнгээр			X	-	Байгалийн нөөц ашигласны төлбөрийн тухай хууль болон бусад
3	Ажилчдыг гэнтийн ослын даатгалд хамруулах	1,000,000*		X		Хүний нөөцийн мэргэжилтэн	
4	Байгаль орчны төлөвлөгөөг аудит хийлгэх	10,000,000*			x	Мэргэжлийн байгууллагаар	
	Нийт	-					

Хүснэгт 10. БОМТ, түүний оролцогч, сонирхогч талуудад тайлагнах, хэлэлцүүлэх хуваарь

№	БОХТ-ний биелэлтийг тайлагнахад оролцогч талууд	Тайлагнах хэлбэр	Мэдээллийн агуулга	Зохион байгуулах хугацааны тов	Тайлагнах зардал, төг	Хариуцан зохион байгуулах албан тушаалтан/ажилтан	Зохион байгуулах газар
1	Дорноговь аймгийн Даланжаргалан сумын засаг даргын тамгийн газарт	Бичгэн тайлан	БОМТ биелэлт	2026.11.1-15	-	БО мэргэжилтэн	
2	Төрийн захиргааны төв байгууллага	Цахим	БОМТ биелэлт	2026.11.1	-	БО мэргэжилтэн	
	Нийт				-		

Зардлын хэлбэр	Нийт зардал
Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөөний зардал	1,000,000
Хог хаягдлын менежментийн төлөвлөгөөний зардал	318,000
Осол эрсдэлийн менежментийн төлөвлөгөөний зардал	200,000
Ногоон байгууламжийн төлөвлөгөө	-
Дүйцүүлэн хамгаалах арга хэмжээ	1,000,000
Орчны хяналт шинжилгээний зардал	1,438,000
Удирдлага зохион байгуулалт	-
БОМТ хэлэлцүүлэх, тайлагнах зардал	-
ДҮН	3,956,000